

**Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан 2023**

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3 сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн зүгээс 2022 оны 6 сарын 9-ний өдөр үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Компанийн засаглалын кодексийн үнэлгээ нь дараах 9 агуулгаас бүрдэх ба үнэлгээний оноог бүрэн хэрэгжсэн, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, хэрэгжүүлээгүйг үндэслэн 0-2 оноогоор үнэлнэ.

**Үнэлгээний агуулга**

№	Агуулга	Авбал зохих нийт оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6
5	Эрсдэлийн удирдлага	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8
8	Компанийн соёл	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>

Дээрх үнэлгээний агуулгын дагуу Ард Кредит ББСБ ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэж ТУЗ-ийн гишүүдэд танилцуулан саналыг тусгасны үндсэн дээр ТУЗ-ийн дарга хянан баталгаажуулсан болно.

**Нэгдсэн үнэлгээний тайлбар**

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн нийт үнэлгээг үндэслэн дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70-90 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 12 сарын 31

<b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>					
<p><i>Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.</i></p>					
<p><b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>  <b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</b></p>					
<b>№</b>	<b>Зүйл</b>	<b>Хэрэгжилт</b>	<b>Тайлбар</b>	<b>Оноо</b>	<b>Хувь</b>
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p><a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a></p> <p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хорооны бүтэц, гишүүдийн эрх, үүрэг, Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.</p>	2	100%
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p><a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a></p> <p>ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан.</p> <p>ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2022/35-01 тоот тогтоолын Хавсралт 2-оор Залгамж халааны бодлогыг баталсан.</p>	2	100%
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p><a href="https://ardcredit.com/mn/reports">https://ardcredit.com/mn/reports</a></p> <p>Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ердийн болон хараат бус гишүүдийн ажлын туршлага болон бусад мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд танилцуулдаг.</p>	2	100%
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<p><a href="https://ardcredit.com/mn/reports">https://ardcredit.com/mn/reports</a></p>	2	100%



	хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.		Компани нь ТУЗ болон хороодын үйл ажиллагааны чиглэл, хороодын бүтэц бүрэлдэхүүн, хорооны эрх үүргийг тодорхойлсон бодлогын баримт бичигтэй ба тус баримт бичигт гишүүдийн ажлын туршлага, мэргэшлийг тодорхойлно.		
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилохдоо чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд ТУЗ-ийн үйл ажиллагааг танилцуулж, холбогдох дүрэм журмын сургалт ордог. Мөн компанийн засаглалын сургалтад суугаагүй бол уг сургалтад хамруулдаг. ТУЗ-ийн гишүүдэд мэдлэг, мэдээлэл олгох сургалтын хөтөлбөрийг баталж хамруулдаг.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлж өгсөн бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах үүрэгтэй. Үүнд ТУЗ-ийн дарга хариуцлага хүлээнэ.	2	100%
Дүн				12	100%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээн					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй ба 3 хараат бус, 6 ердийн гишүүнтэй.	1	50%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a> ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Журамд заасны дагуу компанийн Дотоод аудитын хорооны даргаар Хараат бус гишүүн ажилладаг бөгөөд хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох	2	100%

	<b>хорооны хүсэлтээр оролцоно.</b>		эрхгүй ба шаардлагатай тохиолдолд хүсэлтээр оролцдог.		
9	<b>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a> ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан. Журамд хорооны дарга нь ердийн эсвэл хараат бус гишүүн байх эсэхийг заагаагүй боловч гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байхаар тусгасан. Мөн хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох эрхгүй ба шаардлагатай тохиолдолд хүсэлтээр оролцдог.	2	100%
10	<b>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a> ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан.  ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2022/35-01 тоот тогтоолын Хавсралт 2-оор Залгамж халааны бодлогыг баталсан.	2	100%
11	<b>2.5. ТУЗ-нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, хороодын чиг үүрэг зэргийг зохицуулдаг бол ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ч хорооны чиг, үүрэг, бүтэц, хурлын зохион байгуулалт, шийдвэр гаргалт, гишүүдийн ажлын туршлага, ажиллах журмыг тодорхойлдог.	2	100%
Дүн				9	90%



<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
<b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b>					
12	<b>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a>  ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/15 2 2.8 тоот тогтоолоор "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам"-ыг баталсан. Уг журмаар компанийн үнэн зөв мэдээллийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад хүргэдэг.	2	100%
13	<b>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн засаглалын кодекстой холбоотой засаглалын журам, зааврыг компанийн албан ёсны цахим хуудаст байршуулж олон нийтэд хүргэдэг	2	100%
14	<b>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт"-ын дагуу бэлтгэж толилуулдаг. Санхүүгийн бус тайланд дээрх мэдээллийг тусгадаг.	2	100%
Дүн				6	100%
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
<b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус үр дүнтэй байдлыг хангана</b>					
15	<b>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/procs">https://ardcredit.com/mn/procs</a>  ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Мөн ТУЗ-ийн 2019 оны 7	2	100%





	<i>тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>		Эрсдэлийн хорооны журмаар хорооны бүтэц, гишүүдийн тоо, үүрэг, хариуцлага болон хуралдаан зохион байгуулах, шийдвэр гаргах зэрэг хорооны бүх үйл ажиллагааг зохицуулсан. Хорооны үйл ажиллагааны тайланг жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнах бүрэн боломжтой.		
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд манай компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн боломж нь байгаль орчин болон харилцагчид хэрхэн нөлөөлж буй талаарх мэдээллийг хүргэдэг.  СЗХ-ноос баталсан БОНЗ-ийн үнэлгээний дагуу БОНЗ-ийн үнэлгээг бэлтгэн олон нийтэд мэдээллэх болно.	2	100%
21	<i>5.4. Компани нь комплаенсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплаенсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс компанийн Комплаенсс хариуцсан ажилтныг томилон ажиллуулдаг бөгөөд уг ажилтан нь ТУЗ-д ажлаа тайлагнадаг.	2	100%
Дүн				7	87.5%
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлог тохирсон, шударга, ил тод байна.					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ баталдаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүний цалин, тухайн жилийн төсвийг нээлттэй танилцуулж эхэлсэн.	1	50%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь Гүйцэтгэлийн үнэлгээний журмыг үйл	2	100%

	<b>тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>		ажиллагаандаа мөрддөг бөгөөд уг журмаар ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж цалин, урамшууллын хэмжээг тогтоодог.		
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд өнгөрсөн санхүүгийн жилд гаргасан компанийн санхүү болон үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг тусгадаг. Жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгах бүрэн боломжтой. 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд уг шалгуур үзүүлэлтийг тусгах болно.	1	50%
Дүн				4	66.6%
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>					
<b>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</b>					
25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</b>	Хэсэгчлэн биелүүлсэн	Ард Кредит ББСБ ХК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалттай бөгөөд 13,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй юм. Бид хөрөнгө оруулагч үндэстэнг бий болгох уриатай ажиллаж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудын эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажилладаг. Манай компанийн ТУЗ болон ажилтнууд бүгд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэн, хамтран ажиллах соёлыг аль хэдийн бий болгосон. Компанийн Хөдөлмөрийн дотоод журмаар ажилтантай хамтран ажиллах харилцааг, Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангахыг “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам” -аар зохицуулж байна.  *ТУЗ-ийн 2024.4.15-ны өдрийн ээлжит хурлын 2024/23 тоот тогтоолоор баталсан.	1	50%





26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	<a href="https://ardcredit.com/mn/reports">https://ardcredit.com/mn/reports</a> <a href="https://www.facebook.com/ArdCredit">https://www.facebook.com/ArdCredit</a> Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, улирал бүрийн тайланг хувьцаа эзэмшигчдэд нээлттэй хүргэж хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, ажлын талаарх мэдээллийг өөрсдийн Пэйж хуудсаар болон Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан нээлттэй танилцуулдаг.	2	100%
27	<b>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны <a href="http://www.ardcredit.com">www.ardcredit.com</a> цахим хуудсыг тогтмол ажиллуулж, компанийн засаглал, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хамтран ажиллаж буй байгууллагууд болон компанийн үйл ажиллагаанд гарсан онцлог үйл явдлуудын талаарх мэдээллийг харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудад байнга хүргэж мэдээллээр ханган ажиллаж байна.	2	100%
28	<b>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 22/A/25 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан Хөдөлмөрийн Дотоод журамд ажилтны гомдол, саналыг хүлээн авах, шийдвэрлэх харилцааг нарийн зохицуулсан ба ажилтны нийгмийн асуудал болон мэргэжил, дээшлүүлэх сургалт, хөгжил, карьер төлөвлөлтийн асуудлыг мөн тусгайлан зохицуулсан байна.	2	100%
Дүн				7	87.5%
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b> ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<b>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 2022/21 тоот тогтоолоор Компанийн Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%

	зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.				
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагаанд илэрсэн аливаа хууль бус үйлдэл, зөрчлийн талаарх мэдээллийг Комплайнс хариуцсан ажилтан холбогдох зөрчлийн хамрах хүрээний хувьд хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд, санхүүгийн тайлагнал, залилантай холбоотой асуудлыг Дотоод аудитын хороонд, зээл, эрсдэлтэй холбоотой асуудлыг Санхүү, Зээл, Эрсдэлийн хороонд тус тус мэдэгдэж ажиллаж байна.	2	100%
31	Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх/өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 2022/21 тоот тогтоолоор Компанийн Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%
Дүн				6	100%
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдий эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны <a href="http://www.ardcredit.com">www.ardcredit.com</a> цахим хуудас, "Ard Credit" Facebook хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, зээлдэгч, холбогдох төрийн байгууллага зэрэг бүх оролцогч талуудад зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай тогтмол харилцах цахим сувгийг хөгжүүлсэн бөгөөд <a href="mailto:info@ardcredit.com">info@ardcredit.com</a> имэйл хаяг, <a href="http://www.ardcredit.com">www.ardcredit.com</a> цахим хуудас, "Ard Credit" Facebook	1	50%



			хаягуудаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.  *ТУЗ-ийн 2024.4.15-ны өдрийн ээлжит хурлын 2024/23 тоот тогтоолоор баталсан.		
34	<b>9.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр хуульд заасан хугацаанд зохион байгуулж байна. Хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд ТУЗ -өөр батлуулан хувьцаа эзэмшигчдэд жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлж, тэдний санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бүрэн мэдээллээр хангаж, хууль ёсны эрх ашгийг нь хүндэтгэн ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар асуулт асууж хариулт авах, санал, гомдол, хүсэлтээ илэрхийлэх бүрэн боломжоор ханган ажиллаж байна.	2	100%
35	<b>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, сонирхлын зөрчилтэй их хэмжээний хэлцэл хийх, компанийн өрийг хувьцаагаар солих зэрэг хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн бүтэцтэй холбоотой шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг бөгөөд хэрэв сонирхлын зөрчилтэй асуудал хэлэлцвэл санал хураалтад зөвхөн сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчид оролцдог.	2	100%
36	<b>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</b>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ -ийн 2019 оны 7 дугаар сарын 5 -ны өдрийн 2019/14 тоот тогтоолоор Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа даган мөрдөж байна.	2	100%
<b>Дүн</b>				9	90%
<b>Нэгдсэн дүн</b>				66	91.6%